

Байгаль Орчны Яам
Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Газар
Мэдээлэл Тооцооллын Төв

**МОДИС хиймэл дагуулын
Стандарт Бүтээгдэхүүнийг
ENVI програм хангамж дээр
боловсруулах заавар**

-

Тус зааврыг бичсэн: тус Төвийн ЗТС, ГМС хэлтсийн дарга


..... /М.Одбаяр/

2007 оны 12 дугаар сар 28.

Улаанбаатар хот

МОДИС хиймэл дагуулын Стандарт Бүтээгдэхүүнийг
ENVI програм хангамж дээр боловсруулах заавар


Эрхэм хэрэглэгч таныг интернэт болон өөр эх үүсвэрээс МОДИС хиймэл дагуулан стандарт бүтээгдэхүүн болох *.hdf файлтай болсон гэж үзье. Үүнийгээ боловсруулаад өөрийн болгоод явах олон арга зам бий ч энд бид манай системийн стандарт бүтээгдэхүүн дээр өөрсдийн хэрэглэдэг арга замыг дурдаж байна /нөгөө талаас ENVI програм хангамжийг үнэгүй олж болно/:



Дээрх командаар орсоны дараагаар доорх 'Enter HDF Filenames' цонх нээгдэнэ.




Жишээ болгоод зураг дээр үзүүлсэн файл буюу бүтээгдэхүүн - MOD02QKM /тухайн тохиолдолд МОДИС хиймэл дагуулын үзэгдэх гэрлийн эхний хоёр, 250м-ийн суваг/-ийг нээхэд дотор нь агуулагдаж байгаа бүрэлдэхүүнүүдийн жагсаалт харагдана:



Тухайн тохиолдолд бид дээрээсээ 3 дахь мөр буюу үзэгдэх гэрэлийн ойлтыг бүхэл тоонд масштабласан, 250м-ийн ялгах чадвартай сувгийг сонгож байна.


Тухайн тохиолдолд бид дээрээсээ 3 дахь мөр буюу үзэгдэх гэрэлийн ойлтыг бүхэл тоонд масштабласан, 250м-ийн ялгах чадвартай сувгийг сонгож байна.




Энэхүү зааврын төгсгөлд газарзүйн холболт хийгдсэн мэдээг харуулна.

Манай систем /eOsphere-VxEos/ дээр гарч байгаа зарим бүтээгдэхүүн дагалдах *.met файльтай ба зарим нь ийм файлгүй гарч байгаагаас хамаараад ENVI дээр Газарзүйн холболт, дагалдах *.met гэсэн файльтай бүтээгдэхүүн дээр л хийгдэж чадаж байгаа.


Газарзүйн холболтыг ENVI дээр дараах байдлаар хийнэ.



Дээрх командыг ажиллуулахад доорх цонх гарч ирэх бөгөөд үүн дээр Select Input File – /Оролтын Файлаа Сонгох/ хэсэг дээр ENVI дээр нээгдсэн файлуудын нэрс жагсаагдах бөгөөд тэдгээрээс та өөрийн газарзүйн холболт хийх гэж байгаа файлаа сонгоод ОК дарна.




Дээрх цонх дээр файлаа сонгоод ОК дарахад дараах цонх гарч ирэх бөгөөд газарзүйн холболтоо чухам ямар проекц дээр хөрвүүлэхийг асууж байгаа юм.



Ингэхэд нь бид Geographic Lat/Lon буюу зүгээр уртраг/өргөрөгийн системд хөрвүүлж авна гэж зааж өгч байгаа бөгөөд энд анхаарахад уртраг/өргөрөгийн систем дээр авах боловч Datum-ийг WGS-84 дээр, харин хэмжих нэгж – Units...-г нь Degrees /градус/-аар /програм өөрөө автоматаар/ авч байна.


Тэр доор Output GCP Filename [.pts] /Газрын хяналтын цэг – Ground Control Points (GCP)-үүд агуулах файлын нэр, өргөтгөл нь [.pts]/ гэж асууж байгаа: хэрэв ийм газрын хяналтын цэгүүдтэй хадгалсан файльтай бол түүнийхээ нэрийг өгнө. Хэрэв тийм файлгүй бол юу ч өгөхгүй.

ОК-г дарахад дараах цонх нээгдэнэ.




Энэхүү цонх нь үндсэн хэмжигдэхүүнүүдийг харуулах бөгөөд гаралтын файлын нэрийг асууна. Тухайн тохиолдолд test гэж өгсөн (нэр өгөх мөрийн дээр Choose гэж байгаа түүн дээр дарж яг хаана энэ файлаа үүсгэх гэж байгаагаа бичнэ, ө.х. директорыг зааж өгөөд нэр өгнө).

Ингээд ОК-г дарахад тус бүтээгдэхүүн ENVI програм хангамж дээр газарзүйн холболтонд орно.



Боловсруулалт буюу газарзүйн холболт хийгдэж байх үед дээрх жижиг цонх гарч боловсруулалтын явцыг харуулна (бидний ажигласнаар ойролцоогоор 1 цаг орчим явагдана).

Газарзүйн холболтын боловсруулалт хийгдэж дууссаны дараагаар буюу хиймэл дагуулын мэдээ газарзүйн холболттой болсоны дараа мэдээ дараах байдлаар харагдана.



Газарзүйн холболтонд орсон мэдээн дээр цаашид янз бүрийн боловсруулалт хийж болох бөгөөд улс, аймаг, сумын зэрэг олон янзын вектор файлуудыг тавьж болох юм. Энэхүү зааврыг уншаад та бүхэн МОДИС-ийн мэдээг амжилттай ашиглана гэдэгт итгэлтэй байна.